



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/09

Улиастай

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга С.Амарсайханаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн өвөлжилт хүндэрч буй сумдад ажилласантай холбогдуулан 6,937,500 (зургаан сая есөн зуун гучин долоон мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Чадраабал)-т даалгасугай.

ДАРГА



Т.ӨНӨРБАЯР

Захирамж-2023

8109010060